

ШУТИС-ийн оюутны санаачлагаар бий болсон клубийн эрх, үүрэг

ШУТИС-ийн оюутнуудыг хөгжүүлэн төлөвшүүлэх, хамтран ажиллах, харилцан суралцахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг клубийн системээр оюутанд хүргэх нь үр дүнтэй үйл ажиллагаа юм.

- ШУТИС-ийн оюутны санаачлагаар бий болсон клубүүдийн үйл ажиллагааг ОХУА-наас хариуцан удирдлагаар ханган хамтран ажиллана.
- ШУТИС-ийн оюутны сайн дурын болон мэргэжлийн клуб нь оюутны санал санаачлагад тулгуурлан үүсгэн байгуулагдсан байна. Клуб зөвлөх багштай байна.
- Клуб нь өөрийн танилцуулгыг ШУТИС-ийн вебд байрлуулсан байна.
- Клубүүд ажлын тайлангаа улирал бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гарагт хэлэлцүүлнэ.
- Тайланг үндэслэн дараа улирлын ажлын төлөвлөгөөнд шаардагдах төсвийг холбогдох нэгжүүд, бүрэлдэхүүн сургуулиас авах боломжтой.
- Клубийн ажлын үр дүнг харгалзан клубийн ахлагч, идэвхтэй гишүүд, оюутан багш нарт кредитийн урамшуулал олгох журмын дагуу урамшуулна.
- Шинээр байгуулагдсан клубийн хагас жилийн ажлын үр дүнг харгалзан ОХУА-наас батламж олгоно.
- Клубийн гишүүнчлэлийг нээлттэй хэлбэрээр авна.

КЛУБИЙН ЭРХ:

Үйл ажиллагааг клуб дангаараа болон бусад клубүүдтэй хамтран зохион байгуулах
Клуб өөрийн үйл ажиллагааны чиглэлээр их сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, санал дэвшүүлэх

Клуб нь их сургуулийн аль нэг анги эзэмших болон хамтран эзэмших

Клуб өөрийн үйл ажиллагааны хүрээнд их, дээд сургууль болон улс, олон улсын хэмжээнд тэмцээн уралдаан зохион байгуулах

Клуб өөрийн үйл ажиллагаанд зөвлөгөө авах мэргэжлийн зөвлөх багш болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах

Клуб төсөл хөтөлбөрт хамрагдах, Эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлэн бусад уралдаан тэмцээнд оролцох

КЛУБУУДИЙН ҮҮРЭГ:

Клуб нь гишүүдээ ШУТИС-ийн нэгдсэн арга хэмжээ, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах

Клубүүдийн дунд зохион байгуулж буй нэгдсэн арга хэмжээнд тогтмол оролцох

Тайлангаа цаг хугацаандаа хэлэлцүүлэн дүгнүүлэх

ШУТИС болон бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд оюутанд чиглэсэн шинэлэг 1-2 ажлыг санаачлан хэрэгжүүлэх

ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА